

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН ХӨЛБӨӨНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2023 оны 04 сарын 19-ны өдрийн
03 тогтоомжийн батсгалт 01



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЗАРЧИМ

Нэг. Дүрмийн нийтлэг үндэсэлэл

1. Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын холбооны Удирдах зөвлөл нь Арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Байнгын арбитр нь арбитрын ажиллагааны дүрэмтэй байна" гэж хуульчилсан ёсоор Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрмийг баталж албажуулав.
2. Энэхүү дүрэм нь Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын холбооны Удирдах зөвлөлөөс баталсан журам, бусад дүрэм, журам, заавар, зөвлөмжөөс бүрдэнэ.

Хоёр. Дүрмийн зорилт, зорилго

1. Спортын харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэх дүрэм /цаашид "Дүрэм" гэж товчлох/-ийн үндсэн зорилт нь Олон улсын ба Үндэсний хэмжээнд зохиогдож байгаа спорт, үндэсний спорт уралдаан тэмцээний үеэр болон бусад үед спортын байгууллагын хооронд, эсхүл тамирчдын хооронд, мөн спортын байгууллага-тамирчны хооронд, спортын хороо, холбоо, нийгэмлэг-гишүүдийн хооронд, спортын хороо, холбоо, нийгэмлэг-иргэнийн хооронд, Дасгалжуулагч-спортын байгууллагын хооронд, тамирчин-шүүгч, тамирчин-дасгалжуулагч, мэргэжлийн болон өндөр зэрэглэлийн гадаадын тамирчин, дасгалжуулагчтай байгуулсан Монголын биеийн тамир, спортын байгууллага хоорондын гэрээ, Ажил гүйцэтгэх гэрээ, Худалдах-худалдан авах гэрээ, Хөлсөөр ажиллах гэрээ, Өндөр зэрэглэлийн тамирчин, Эд хөрөнгөтэй холбоотой үүссэн, зөвхөн спорттой холбоо бүхий санал зөрөлдөөн, маргааныг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрмээр шийдвэрлэхдээ Олон улсын болон Монголын эрх зүйн ерөнхий нийтлэг шаардлагад нийцүүлэхээс гадна олон улсын стандартад, Арбитрын "Загвар хууль", Олон улсын Спортын конвенци, Олимпын Харти, Дэлхийн допингийн эсрэг дүрэм болон олон улсын стандарт, олон улсын худалдааны практикыг баримтлана. Монголын Олон улсын ба Үндэсний Спортын Арбитр нь Олон улсын болон Монгол Улсын хууль тогтоомж, түүнчлэн олон улсын стандарт, Арбитрын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Олон улсын спортын конвенц, Олимпын харти, Дэлхийн допингийн эсрэг дүрэм болон бусад хууль тогтоомжийн ерөнхий шаардлагад нийцсэн байна.

- 2.2 Энэхүү дүрмийн зорилго нь тухайн төрөлжсөн спортын хүрээнд үүссэн аливаа маргааныг зөвхөн хуульд захирагдан, шударга ёсны зарчимд нийцүүлэн, алагчлалгүй, талуудын тэгш эрхийг бүрэн хангаж, голчтой, шударгаар шийдвэрлэхэд оршино.

**Гурав. Монголын Олон Улсын ба Үндэсний Спортын
Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн үйлчлэх хүрээ, зарчим**

- 3.1. Энэхүү дүрмийн үйлчлэх цар хэмжээ нь Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитр /цаашид "Спортын Арбитр" гэх/-аар тус арбитрын харьяалалд хамаарах Олон улсын болон Дотоодын арбитрын маргаан шийдвэрлэх үйл ажиллагааны хүрээгээр хязгаарлагдана.
- 3.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол тухайн маргаанд Спортын Арбитрын ажиллагаа эхэлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрмийг баримтална.
- 3.3. Энэхүү дүрэмд заагаагүй болон талуудын Спортын Арбитрын хэлэлцээрээр тохиролцоогүй аливаа ажиллагааг Спортын Арбитрын бүрэлдэхүүн аль тохиромжтой, аль нэг талын эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр явуулна.
- 3.4. Спортын Арбитрын үйл ажиллагаанд спортын байгууллагыг өмчийн хэлбэрээр нь, мэргэжлийн, мэргэжлийн бус ангиллаар, тамирчныг улсын харьяалал, харьяат бус гэдгээр нь, арьс өнгө, шашин шүтлэг, нас, хүйс, мэргэжил боловсрол, багийн харьяалал, спортын цол, зэрэг, хөрөнгө чинээг үл харгалзах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим дээр тулгуурлан явагдана.
- 3.5. Монголын хүүхдийн, оюутны, үндэсний, бүх ард түмний спортын их наадам, Үндэсний хэмжээний болон Монгол Улсад зохиогдож буй олон улсын хэмжээний тэмцээн, уралдаан, наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээн, Үндэсний их баяр наадам /Үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, үндэсний сурын харваа/, орон нутгийн /аймаг, сум, баг/ чанартай, салбарын, байгууллагын зэрэг бүхий л спортын арга хэмжээний хүрээнд хийгдсэн аливаа гэрээ, дүрэм, журам, хэлэлцээрээс үүссэн маргааныг зохицуулахад энэхүү дүрэм хамаарна.
- 3.6. Арбитрын тухай хуульд заасан заавал дагаж мөрдөх заалтаас бусад ажиллагааг энэхүү дүрэмд заасны дагуу хэрэгжүүлнэ.
- 3.7. Энэхүү дүрмийн оноосон нэр томъёо дараах утга, агуулгыг илэрхийлнэ.
“**Загвар хууль**” гэдэг нь НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комиссоос 1985 оны 06 дугаар сарын 21-ний өдөр гаргасан “Олон Улсын Арилжааны Арбитрын “Загвар хууль”-ийг;
“**Олимпын Харт**” гэдгийг Олон улсын олимпын хорооноос баталж 2011 оны 7 дугаар сард хүчин төгөлдөр болсон баримт бичгийг;
“**Дэлхийн допингийн эсрэг дүрэм**” нь 2003 онд анх батлагдаж 2004 онд хүчин төгөлдөр болсон. Уг дүрэмд нийт дөрвөн удаа өөрчлөлт орсон бөгөөд 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр анхны өөрчлөлт, 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр хоёр дахь удаагийн өөрчлөлт, 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр гурав дахь удаагийн өөрчлөлт, 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр дөрөв дэх удаагийн өөрчлөлтийг тус тус оруулсан байна. 2021 оны шинэчлэгдсэн Дэлхийн Допингийн эсрэг дүрэм нь 2021 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснийг;

“**Биеийн тамир, спортын тухай хууль**” гэж Монгол Улсын Их хурлаас 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр батлаж 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн хуулийг хэлнэ. Энэ хуулийн зорилт нь биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион

байгуулалт, үйл ажиллагаа, эрх зүйн үндсийг тодорхойлж, биеийн тамир, спортын салбарын харилцааг зохицуулахад оршино.

“Олон улсын стандарт” гэж Дэлхийн Допингийн эсрэг дүрмийг дэмжих зорилгоор WADA-аас баталсан стандартыг хэлнэ. Олон улсын стандартыг дагаж мөрдөх (өөр өөр стандарт, практик эсвэл процедурын эсрэг) нь олон улсын стандартад заасан журмыг зохих ёсоор гүйцэтгэсэн гэж үзнэ. Олон улсын стандартад олон улсын стандартын дагуу гаргасан техникийн баримт бичиг мөн багтна.

“Сэргээшийн эсрэг тунхаглал” гэж нь Спортод сэргээшийн эсрэг Копенгагены тунхаглалыг хэлнэ;

“Улсын Дээд шүүхийн тогтоол” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасныг;

Дөрөв. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ

- 4.1. Арбитрын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Үндэсний баяр наадмын тухай хууль, хуулийг тайлбарласан Улсын Дээд шүүхийн тогтоол, тухайн спортын дүрэм, журам, (Дэлхийн Допингийн эсрэг дүрэм болон Олон улсын стандартаар хязгаарлагдахгүйгээр) НҮБ-ын олон улсын арилжааны эрхийн комиссоос гаргасан арбитрын “Загвар хууль”, Олимпын Харт, дэлхийн бусад улс орнуудын арбитрын хэрэг шийдвэрлэж буй нийтлэг жишиг, олон улсын спортын харилцааны ёс, зан заншил, уламжлал нь хэрэг, маргааныг шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ, харгалзах эх сурвалж болно.
- 4.2. Арбитрын бүрэлдэхүүн хэргийн агуулгад тохирох хэмжээгээр талуудын сонгосон эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Талууд ийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн талуудын байгуулсан гэрээний заалт болон тохиромжтой гэж үзсэн эрх зүйн хэм хэмжээ, олон улсын гэрээ, зан заншлыг харгалзан үзнэ. (Энэхүү заалт нь допингийн хэрэг, маргаанд хамаарахгүй бөгөөд допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн үед lex mitior зарчмыг тухайн хэргийн нөхцөл байдалд зохих ёсоор хэргийг хянан хэлэлцэж буй арбитрын бүрэлдэхүүн тогтоогоогүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй допингийн эсрэг дүрмээр зохицуулагдана).
- 4.3. Зөвхөн талууд шууд эрх олгосон онцгой тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн аливаа хуулийг хэрэглэхгүйгээр, шударга гэж үзсэн ёс зүйн хэм хэмжээ, амьдралын хар ухааны зөв сургамжит ухагдахуун, ардын ухаалаг ур дүй, тухайн улс гүрний зан заншилд нийцүүлэн маргааныг шийдвэрлэж болно. (Энэхүү заалт нь допингийн хэрэг, маргаанд хамаарахгүй).
- 4.4. Гадаад улсын хуулийг хэрэглэх тохиолдолд тухайн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт, хуулийн албан ёсны тайлбар, тухайн төрлийн хэргийг хэрхэн шийдвэрлэж ирсэн практикийг харгалзан жишиж үзэж болно.
- 4.5. Гэхдээ хэрэг нь олон улсын байсан ч Спортын Арбитр хэргийг хянан шийдвэрлэхдээ Арбитрын тухай Монгол Улсын хуулийн “Арбитрын хэлэлцээр ба шүүхэд нэхэмжлэл гаргах, арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад шүүхээс авах арга хэмжээ, зардал, хохирлыг гаргуулах, түр арга хэмжээг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх, шүүхээс авах түр арга хэмжээ, нотлох баримт бүрдүүлэхэд шүүхээс туслалцаа үзүүлэх, үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх, үндсэн шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах” зохицуулалтыг хэрэглэнэ.

- 4.6. Допингийн маргаан нь энэхүү дүрэмд хамаарахгүй бөгөөд допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн үед lex mitior зарчмыг тухайн хэргийн нөхцөл байдалд зохих ёсоор хэргийг хянан хэлэлцэж буй арбитрын бүрэлдэхүүн тогтоогоогүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй допингийн эсрэг дүрмээр зохицуулагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

СПОРТЫН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Тав. Нэхэмжлэл гаргах

- 5.1. Спорт болон спортын байгууллагатай холбоотой өөрийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхол хохирсон гэж үзэж байгаа хуулийн этгээд, иргэн тухайн спортын холбоо, нийгэмлэгт маргааныг шийдвэрлэх бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн байхгүй, эсхүл уг маргааныг шийдвэрлэхээс татгалзсан, энэхүү дүрэмд заасан хугацаанд маргааныг шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрч байгаа бол Олон улсын ба үндэсний спортын арбитрт шууд хандах эрх нь нээлттэй.
- 5.2. Нэхэмжлэлийг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын Ажлын албанд биечлэн эсхүл баталгаат шуудангаар ирүүлж болно.
- 5.3. Нэхэмжлэлд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:
- 5.3.1. Талуудын нэр, хаяг, утас, цахим шуудан, шуудангийн хаяг, эрх бүхий этгээд, төлөөлөгчдийн мэдээлэл, итгэмжлэл болон холбоо барих бүх мэдээлэл
 - 5.3.2. Нэхэмжлэлийн шаардлага, мөнгөн дүн
 - 5.3.3. Нэхэмжлэл гаргах болсон үндэслэл, маргааны агуулгыг тодохой заах
 - 5.3.4. Спортын арбитрын хэлцэл, гэрээ болон нотлох баримт бичиг
 - 5.3.5. Спортын арбитрын зардал төлсөн баримт
 - 5.3.6. Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулах бол итгэмжлэл
 - 5.3.7. Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой гэж үзсэн мэдээлэл, баримтуудыг гарган өгч болно.
- 5.4. Нэхэмжлэлд дараах мэдээллийг нэмэлтээр тусгаж болно. Үүнд:
- 5.4.1. Нэхэмжлэлийн хууль зүйн үндэслэл эсхүл нэхэмжлэлээ дэмжсэн нэмэлт тайлбар
 - 5.4.2. Спортын арбитрын ажиллагаа явуулах газар, хэл, хэрэглэх хуулийн талаарх тусгайлсан хүсэлт Хэдэн арбитрчаар уг маргааныг шийдвэрлүүлэх тухай хүсэлт, арбитрч сонгосон болнэрийг заасан тухай мэдэгдэл
- 5.5 Нэхэмжлэлийг Спортын арбитрын Ажлын алба хуульд заасан бүрдэл хангагдсан гэж үзвэл хүлээн авч, нэхэмжлэл, түүнд хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг минутыг бүртгэн, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулж нэхэмжлэл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.
- 5.6 Нэхэмжлэл, түүний хавсралт, хариуцагчийн тайлбар, сөрөг нэхэмжлэл түүний хавсралтаар ирүүлж буй бүх баримт бичгийг Спортын арбитр, хэргийн оролцогчид болон арбитрчдын тоогоор хувилж өгнө.
- 5.7 Нэхэмжлэлийг Монгол хэл дээр, эсхүл гадаад хэл дээр гаргаж болох бөгөөд нэхэмжлэл, түүнд хавсаргасан аливаа баримт бичиг гадаад улсын хэл дээр үйлдэгдсэн бол Монгол хэл рүү, эсхүл тухайн хэл рүү баталгаат орчуулгаар орчуулуулан, шаардлагатай гэж үзвэл нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.
- 5.8 Хэрэв үндсэн хуралдаан эхэлмэгц шаардлага хангасан сөрөг нэхэмжлэл гаргасан, эсхүл

нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн бол талуудад шинээр гаргасан нэхэмжлэлтэй танилцах, дахин тайлбар хийх, шинэ нотлох баримт бүрдүүлэх боломж олгож хуралдааныг хойшлуулж болно. Гэхдээ нөгөө тал нь сөрөг нэхэмжлэл, нэхэмжлэлийн өөрчилсөн шаардлагыг хүлээн зөвшөөрч хуралдааныг үргэлжлүүлэх хүсэлт гаргасан бол хуралдааныг ердийн журмаар үргэлжлүүлнэ.

5.9 Ажлын албанаас Спортын арбитрын хэрэг үүсгэсэн тухай мэдэгдлийг нэхэмжлэгч, хариуцагч нарт хүргүүлнэ.

Зургаа. Нэхэмжлэлийг буцаах

- 6.1. Нэхэмжлэлийг буцаах үндэслэлүүд Үүнд:
 - 6.1.1. Спортын арбитрын харьяаллын бус маргаан
 - 6.1.2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.3 болон шүүх, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар тусгайлан харьяалуулсан маргаан арбитрын харьяалалд үл хамаарна.
 - 6.1.3. Эрхийн чадамжгүй буюу төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан
 - 6.1.4. Нэхэмжлэлд дурдсан асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн буюу арбитрын хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол
 - 6.1.5. Нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн шаардлага хангагдаагүй
- 6.2. Нэхэмжлэлийг бүрдүүлбэрийн шаардлагаар буцаах бол тодорхой хугацаа зааж (7-14 хоног), бүрдүүлбэрийг нөхөн гүйцээлгэх ба харин тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол нэхэмжлэлийг буцаана.

Долоо. Нэхэмжлэлийн үнэ

- 7.1. Нэхэмжлэлийн үнийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
 - 7.1.1. Мөнгө төлүүлэхээр шаардсан нэхэмжлэлд нэхэмжилж байгаа мөнгөн дүнгээр,
 - 7.1.2. Гэрээ хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай нэхэмжлэлд уг гэрээхэлцлийн үнийн дүнгээр, Эд хөрөнгө гаргуулахаар шаардсан нэхэмжлэлд нэхэмжилж байгаа эд хөрөнгийн үнийн дүн, үнийн дүнг тодорхойлох боломжгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр,
 - 7.1.3. Эрхийн харилцааг хүлээн зөвшөөрөх буюу өөрчлөх тухай нэхэмжлэлд нэхэмжлэл гаргах үе дэх эрхийн харилцааны зохицуулах зүйлийн өртгөөр,
 - 7.1.4. Тодорхой үйлдэл буюу эс үйлдлийн тухай нэхэмжлэлд нэхэмжлэгчийн эд хөрөнгийн сонирхлын талаар байгаа мэдээллийг үндэслэн заана.
 - 7.1.5. Хэд хэдэн шаардлага тавьсан нэхэмжлэлд, шаардлага бүрийн үнийн дүнг тус бүрт нь тодорхойлох бөгөөд нэхэмжлэлийн үнийг бүх шаардлагын нийлбэр дүнгээр тодорхойлно.
- 7.2. Хэрэв нэхэмжлэгч нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлоогүй эсхүл буруу тодорхойлсон байвал арбитрын бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар, нэхэмжлэгчийн хүсэлт, эсхүл хариуцагчийн шаардлагаар нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлно.
- 7.3. Хэрвээ нэхэмжлэлийн үнийн дүнг тогтооход бэрхшээлтэй онцгой тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоолгож болно.

Найм. Арбитрын зардал

- 8.1. Спортын Арбитрын зардлын хэмжээ, төлөх, буцаах, зардлыг хуваарилах журмыг хуулиар болон “Арбитрын үндсэн зардал болон нэмэлт зардлын хэмжээг тооцох журам”-аар тодорхойлно.
- 8.2. Спортын Арбитрын зардал нь үндсэн болон нэмэлт зардлаас бүрдэх бөгөөд үндсэн зардлыг арбитрт нэхэмжлэл гаргахдаа урьдчилан төлнө.
- 8.3. Үндсэн зардалд арбитрчдын хөлс болон захиргааны зардал багтана.
- 8.4. Талууд арбитрын ажиллагааны явцад гарсан дараах нэмэлт зардлыг арбитрынбүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд төлнө.
 - 8.4.1. Шинжээчтэй холбогдон гарах зардал, арбитрын шийдвэрээр гүйцэтгэсэн ажиллагаа нь тухайн этгээдийн үндсэн ажил үүрэгт хамаарахгүй бол тэдгээрийн ажлын хөлс,
 - 8.4.2. Үзлэг хийхэд гарсан зардал, албан томилолтын зардал,
 - 8.4.3. Арбитрын байнгын байрлах газраас өөр газарт арбитрын ажиллагаа, хуралдаан явуулсантай холбогдсон зардал,
 - 8.4.4. Шуудангийн зардал, хэлмэрчлэл, орчуулга хийх, гэрчийн зардал,
 - 8.4.5. Бусад зардал.

Ес. Спортын арбитрын ажиллагааг эхлэх, тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах

- 9.1. Спортын арбитрын хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны явц, шийдвэрийг ёсчлох, албажуулах ажиллагааг Спортын Арбитрын Ажлын алба гүйцэтгэнэ.
- 9.2. Хариуцагч талд мэдэгдэл болон нэхэмжлэлийг энэхүү дүрмийн 10 дугаар зүйлд зааснаар хүргүүлснээр арбитрын ажиллагааг эхэлсэнд тооцно.
- 9.3. Спортын Арбитрын Эвлэрүүлэн зуучлах төвөөр маргаанаа шийдвэрлүүлэх эсэхийг талууд арбитрийн ажиллагаа эхэлсэнээс хойш 7–14 хоногт зөвшилцөж, бичгээр саналаа тус тусдаа ирүүлнэ. Хэрэв дээр дурьдсан хугацаанд хариу өгөөгүй, өөр өөр саналтай байгаа бол хэрэг, маргааны талаар Спортын арбитрын хэрэг үүсгэсэн шийвэрийг Ажлын албаны дарга 14 хоногын доторгаргана.
- 9.4. Хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцож байгаа тохиолдолд сүүлчийн этгээдэд мэдэгдэл хүргэгдсэнээр хугацааг тоолно.
- 9.5. Спортын арбитрын хэрэг үүсгэсэн тухай шийдвэр, Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэм, үндсэн болон нэмэлт зардал тооцох журам, арбитрчдын нэрсийн жагсаалт болон нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтыг талуудад гардуулна.
- 9.6. Хэрэв талууд тогтоосон хугацаанд хариу тайлбар ирүүлээгүй, арбитрчаа томилоогүй бол энэ дүрмийн дагуу арбитрын ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 9.7. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагчид оролцож болох бөгөөд үндсэн болон сөрөг нэхэмжлэл, тайлбаруудыг тус бүрт нь хүргүүлнэ.
- 9.8. Хариуцагч үндсэн нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болохоос өмнө сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг нэхэмжлэл нь энэ дүрмийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Арав. Бичиг баримтыг хүлээн авах, хүргүүлэх, хугацаа тоолох

- 10.1. Хэргийн талууд эсхүл тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид маргаанд холбогдох бүхий л баримт бичиг, мэдэгдлийг Спортын Арбитрт хүрэлцэн ирж авах бөгөөд боломжгүй бол

- талуудын мэдэгдсэн эсхүл хамгийн сүүлд мэдэгдэж байсан, түүний үйл ажиллагаа явуулдаг, эсхүл байнга оршин байгаа, мөн үйл ажиллагаагаа байнга явуулдаг газар, шуудангийн хаягаар, харин эдгээрийг тогтоох боломжгүй бол гэрээний эсхүл эрх бүхий байгууллагаас ирүүлсэн лавлагаанд дурдсан хаягаар баталгаат шуудангаар ажлын 3 хоногт хүргүүлнэ. Ийнхүү хүргүүлснээ нотлох баримтаар баталгаажуулсан бол хүлээн авсанд тооцно.
- 10.2. Баримт бичиг, мэдэгдлийг факс, телеграмм, цахим шуудан болон бусад техник технологийн хэрэгслийг ашигласан, шаардлагатай онцгой тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар хүргэсэн, хүргэх оролдлого хийсэн /факс, мессеж, и-мэйл хаягаар г.м./ тэмдэглэл үйлдэх зэрэг боломжит бүх арга, хэрэгслийг ашигласан байвал хүлээн авсантай адилтган тооцно.
- 10.3. Бичиг баримт, мэдэгдлийг энэ зүйлийн 10.2, 10.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу хүргэсэн өдрийг зохих хугацаанд хүлээн авсан өдөрт тооцно.
- 10.4. Мэдэгдэл, баримт бичгийг хүлээн авсан, арбитрын ажиллагааны өдрийг хуанлийн тооллоор, цагийг тухайн ажиллагаа явагдах улс, орны орон нутгийн цагаар тодорхойлно.
- 10.5. Хэрэв тогтоосон хугацааны сүүлийн өдөр нь амралтын, нийтээр амрах баярын ёслолын өдөр эсхүл хүлээн авагчийн оршин байгаа улс орон, бүс нутгийн нийтийг хамарсан баяр, амралтын өдөр бол энэ хугацаа нь дараагийн ажлын эхний өдрөөр тооцогдоно.
- 10.6. Хугацааг хуанлийн өдрөөр тоолох бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс тоолно.

Арван нэг. Спортын арбитрын бүрэлдэхүүн

- 11.1. Талууд хэрэг үүсгэсэн тухай шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын арбитрчдын бүрэлдэхүүний нэрсийн жагсаалтаас арбитрчийг сонгож, томилсон тухайгаа бичгээр мэдэгдэнэ.
- 11.2. Мэтгэлцэгч талууд хэрэг маргааныг шийдвэрлэх арбитрын бүрэлдэхүүний тоог санал нэгтгэйгээр тогтоож болно. Гэхдээ арбитрын бүрэлдэхүүн заавал сондгой тоотой 1 буюу 3 байх зарчмыг баримтална.
- 11.3. Хэрвээ Талууд арбитрчийн тоог нэг байхаар тохиролцсон, эсхүл аль нэг тал нь нэг байх санал гаргасан, тухайн саналыг нөгөө тал нь хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор зөвшөөрсөн, эсхүл хариу өгөөгүй буюу татгалзаагүй тохиолдолд нэг арбитрчаар шийдвэрлүүлэх хүсэлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох бөгөөд арбитрчийг Арбитрын Ерөнхийлөгч ажлын 3 хоногт багтаан томилно.
- 11.4. Арбитрын хэрэг үүсгэсэн тухай шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор талууд арбитрчаа томилоогүй, эсхүл нэг тал нь арбитрчаа томилсон бол нэг арбитрчтай арбитрын ажиллагааг явуулна. Хэрэг хянан шийдвэрлэх арбитрчаар нэг талын томилсон арбитрчийг эсхүл өөр арбитрчийг томилох эсэхийг Арбитрын Ерөнхийлөгч эцэслэн шийдвэрлэнэ.
/Энэ хэсгийг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр нэмсэн./
- 11.5. Хэрвээ талууд өөр өөр саналтай бол хэрэг маргааныг шийдвэрлэх арбитрын бүрэлдэхүүний тоо 3 арбитрч байна.
- 11.6. Талууд арбитрчаа сонгохдоо тухайн арбитрчийн боловсрол, мэдлэг, ажлын дадлага туршлага, ёс зүй, хэрэг маргааныг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн өөрийн итгэл үнэмшилд тулгуурлана. Талуудын сонгож байгаа арбитрч нь тухайн сонгосон талд үйлчлэх, зөвлөлгөө өгөх үүрэггүй учраас талуудаас хараат бус байна.
- 11.7. Спортын байгууллага, холбоо, хороо, нийгэмлэг болон тэдгээрийн гишүүн, тамирчдаас нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох тохиолдолд тухайн байгууллагаас нэр дэвшиж, томилогдсон Арбитрчыг сонгохгүй.

- 11.8. Талуудын сонгосон арбитрчид Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын арбитрчдын бүрэлдэхүүний нэрсийн жагсаалтаас арбитрчийг сонгож санал нэгдвэл даргалагч арбитрчийг томилно.
- 11.9. Талуудын томилсон арбитрчид даргалагч арбитрчийн талаар санал зөрсөн бол Арбитрын Ерөнхийлөгч арбитрч нарын санал зөрсөн арбитрчаас өөр арбитрчийг даргалагчаар томилно.
- 11.10. Мэдэгдэлд заасан хугацаанаас өмнө талууд арбитрчаа, арбитрчид даргалагч арбитрчийг Арбитрын Ерөнхийлөгчөөр томилуулах хүсэлтийг гаргаж болно.
- 11.11. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцох тохиолдолд талууд арбитрчийн тоог өөрөөр тохиролцоогүй бол нэхэмжлэгчид хамтран нэг арбитрчийг, хариуцагчид хамтран нэг арбитрчийг 30 хоногийн дотор тус тус томилно.
- 11.12. Арбитрын Ерөнхийлөгч арбитрчийг томилохдоо талуудын шаардлагыг хангаж байгаа эсэх, мэргэжил, мэргэшсэн байдал, дадлага туршлага, арбитрын хэргийг шийдвэрлэхэд оролцсон удаа, хэргийн болон ажлын ачаалал, цаг зав, хэлний чадвар болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- 11.13. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүний даргалагч, эсхүл нэг арбитрын бүрэлдэхүүн нь хуульч мэргэжилтэй байна.
- 11.14. Арбитрчыг татгалзан гаргах, арбитрч үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бол Арбитрын тухай хуулийн 14, 15, 16, 17 дугаар зүйлд заасан асуудлаар гаргасан Арбитрын Ерөнхийлөгчийн шийдвэр эцсийнх байна.
- 11.15. Сонгогдсон Арбитрч нь энэхүү дүрэмд заасны дагуу өөрсдийн үйл ажиллагааг хараат бус, нөлөөнд автагдахгүйгээр явуулах мэдэгдэлд гарын үсэг зурна.

Арван хоёр. Арбитрчын хараат бус байдал, идэвхи

- 12.1. Спортын арбитрын Арбитрч нь хараат бус, бие даасан байна. Арбитрч тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ аливаа хөндлөнгийн нөлөөнд автахгүйгээр, зөвхөн өөрийн мэргэжлийн мэдлэг, боловсрол, ажлын ур чадвар, ёс зүйд түшиглэн, хуульд захирагдан үнэнч шударгаар ажиллана.
- 12.2. Спортын Арбитрч нь орон тооны бус, өөр ажил, албан тушаал эрхэлдэг онцлогтой боловч арбитрчаар сонгогдсоноо хүлээн зөвшөөрсөн, нөлөөллийн мэдүүлэгт гарын үсэг зурсан үеэс хойш арбитрын аливаа ажиллагаанд өөрийн цаг заваа зориулан, идэвхи санаачилгатай, хуулийн хугацаанд үүргээ гүйцэтгэхэд түлхүү анхаарч ажиллана. Энэ нь тухайн арбитрчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт болох бөгөөд сонгуулийн өрсөлдөөнд танилцуулах баримт бичиг болно.
- 12.3. Спортын Арбитрчаар томилогдох хүсэлт авсан этгээд тухайн маргаанд ажиллахаа хүлээн зөвшөөрөхөөс өмнө талуудын талаарх мэдээлэл, нэхэмжлэлтэй танилцан өөрийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал байгаа болон ажиллах цаг зав боломжгүй талаар Спортын арбитрын Ажлын албанд мэдэгдэнэ. Үүнд:
 - 12.3.1. Талуудын харилцан тохиролцсон шаардлагыг хангаж байгаа эсэх
 - 12.3.2. Талуудтай аливаа маргаантай асуудлаар шүүх, арбитраар хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч, арбитрч, хэргийн оролцогч, зохигч, гуравдагч этгээд, өмгөөлөгч, гэрч, шинжээч, хэлмэрч, орчуулагчаар оролцож байсан
 - 12.3.3. Талууд, өмгөөлөгч, төлөөлөгч нь арбитрын бүрэлдэхүүнд байгаа арбитрчтай төрөл садан, хувийн харилцаатай, сүүлийн 3 жилийн байдлаар захирах, захирагдах харилцаанд байсан

- 12.3.4. Талуудад мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж байсан, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчидтэй хамтран ажиллаж байсан, нэгдмэл сонирхолтой
- 12.3.5. Энэ дүрмийн 11.6-д заасан арбитрчийг сонгосон
- 12.3.6. Бусад нөхцөл байдлын улмаас хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээтэй байдал байгаа бол
- 12.4. Талууд болон сонирхогч этгээдийн хүсэлтээр Ажлын алба арбитрчийн хараат бус, эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал байгаа эсэх талаар холбогдох байгууллагаас мэдээлэл, лавлагаа авч болно.
- 12.5. Арбитрч нь дээрх нөхцөл байдал байгаа бол томилогдохоосоо өмнө болон томилогдсоныхоо дараа аль ч үед арбитрын бүрэлдэхүүн, Ажлын алба, талуудад бичгээр мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ийнхүү мэдэгдэхдээ арбитрчаар ажиллах, эсхүл татгалзах тухай саналаа ирүүлнэ.

Арван гурав. Арбитрчийг татгалзах үндэслэл

- 13.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрчийг зөвхөн энэхүү дүрмийн 12.3 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзан гаргана.
- 13.2. Арбитрчаар томилогдсон аль ч арбитрчийн хараат бус байдлын мэдүүлгийг талууд гардан авснаас хойш 7 хоногийн дотор илэрхий болсон үндэслэлээр түүнийг татгалзан гаргах тухай үндэслэл бүхий хүсэлтийг баримтаар баталгаажуулан гаргаж болох бөгөөд хүсэлтийг арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэх ажиллагаанд тухайн арбитрч оролцохгүй бөгөөд зөвхөн өөрийн санал, үндэслэлийн талаар бичгээр илэрхийлнэ. Арбитрч нар татгалзан гаргах хүсэлтийн талаар нэгдсэн саналд хүрч чадаагүй тохиолдолд тухайн хүсэлтийг Ерөнхийлөгч эцэслэн шийдвэрлэнэ.
- 13.3. Арбитрчийг нэг аль талаас татгалзан гаргах тухай хүсэлт гаргаж байгааг нөгөө тал зөвшөөрсөн, эсхүл арбитрч өөрөө татгалзан гаргах хүсэлт гаргасныг бүрэлдэхүүн хүлээн авсан бол тухайн арбитрчийн уг хэрэгт оролцох бүрэн эрх дуусгавар болно.

Арван дөрөв. Арбитрчийг нөхөн томилох

- 14.1. Арбитрчийг татгалзан гаргасан буюу арбитрч үүргээ удаан хугацаагаар гүйцэтгэх боломжгүй болсон, эсхүл арбитрчаар ажиллахаас өөрөө татгалзсан тохиолдолд түүний эрх, үүрэг дуусгавар болж арбитрчийг нөхөн томилно.
- 14.2. Арбитрч нь ёс зүйн зөрчил гаргасан, хууль, дүрмээр тогтоосон хугацаанд үүргээ зохих ёсоор биелүүлэхгүйгээс талуудад чирэгдэл учруулсан, хүнд суртал, идэвхи санаачилгагүй байдал нь арбитрын нэр хүнд, албаны нэр төрд харшилсан бол Ерөнхийлөгч арбитрчийн эрх, үүргийг тухайн хэргийн хувьд дуусгавар болгож арбитрчийг шинээр нөхөн томилно. Энэ тухай талуудад болон арбитрчдад мэдэгдэж тайлбар гаргах хугацааг олгоно.
- 14.3. Арбитрын бүрэлдэхүүн нөхөн томилогдсон бол өмнөх бүрэлдэхүүний ажиллагаанаас хойш үргэлжлүүлэн явуулах эсэхийг талуудтай тохиролцон тодорхойлно.
- 14.4. Талуудын томилсон аль нэг арбитрчийн эрх, үүрэг дуусгавар болж, нөхөн сонгогдсон буюу томилогдсон тохиолдолд даргалагч арбитрчийг хэвээр үлдээх эсэхийг тухайн бүрэлдэхүүн талуудын саналыг харгалзан шийдвэрлэнэ. Хэрвээ талууд өөр өөр санал гаргасан бол даргалагч арбитрчийг энэхүү дүрмийн дагуу ердийн журмаар сонгоно.

Арван тав. Арбитрын шийдвэрийг баталгаажуулах

- 15.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын Арбитрын шийдвэрийг баталгаажуулах тухай хүсэлтийг үндэслэлтэй, зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн биелэлтийг урьдчилан хангах хуульд нийцсэн арга хэмжээг авч болно.
- 15.2. Арбитрын ажиллагааны өмнө, эсхүл ажиллагааны явцад шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авхуулах зорилгоор шүүхэд хүсэлт гаргаж болно. Энэ нь арбитрын хэлэлцээртэй ямар нэг байдлаар зөрчилдсөн гэж үзэхгүй.

Арван зургаа. Арбитрын ажиллагаа явуулах арга, хэлбэр

- 16.1. Арбитрын хуралдааныг талууд арбитрт итгэл үзүүлсэн бол нотлох баримт дээр түшиглэн талуудыг оролцуулахгүйгээр хуралдах, эсхүл талуудыг оролцуулан мэтгэлцэх хуралдаан, эсхүл виедо болон теле хуралдаан, мөн тусгай техник хэрэгсэл ашиглан арбитрын үйл ажиллагааны бүхий л явцыг харуулсан цахим хуралдаан хэлбэрээр явуулж болно.
- 16.2. Арбитрын хуралдааныг видео-хуралдаан, эсхүл хэргийн оролцогч, гэрч, шинжээч нарын саналыг видео хуралдаан болон теле-хуралдааны хэлбэрээр явуулж болно. Хэргийн оролцогчид зөвшөөрсөн бол гэрч болон шинжээчээс урьдчилан мэдүүлэг авч хуралдаанд биечлэн оролцохоос чөлөөлж болно.
- 16.3. Арбитрын бүрэлдэхүүн талуудад эрх тэгш байдлаар хандаж, ажиллагааны зохих шат бүрийг шуурхай бөгөөд үр дүнтэй, ажил хэрэгч явуулахад бүхий л хүчин чармайлт гаргаж, шаардлагатай гэж үзсэн, талууд хүлээн зөвшөөрөхүйц арга, хэлбэрээр ажиллагааг явуулна. Үүнд дугуй ширээний зарчмаар буюу мэтгэлцэхдээ суудлаасаа заавал босохгүйгээр, бичиг баримтаа чөлөөтэй ашиглах боломжоор хангагдаж, онц шаардлагатай үед өмгөөлөгчтэйгөө болон нөгөө талтайгаа зөвшилцөх боломжоор хангагдаж, аль болох захирамжлах аргаас татгалзах хэлбэрээр явуулна.
- 16.4. Арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд нь түргэн шуурхай явуулахын тулд талуудын саналыг харгалзан арбитрын хэлэлцээрт үл харшлах зохих процессийн журам болон арбитрын ажиллагааны завсарын хуваарийг тогтоож, харилцан тохиролцсон хугацааг сунгах эсхүл богиносгож болно.
- 16.5. Арбитрын бүрэлдэхүүн ажиллагааны үр дүнтэй байдлыг хангахын тулд талуудын саналыг харгалзан арбитрын хэлэлцээрт үл харшлах зохих процессийн журам болон арбитрын ажиллагааны завсарын хуваарийг тогтоож, харилцан тохиролцсон хугацааг сунгах эсхүл богиносгож болно.
- 16.6. Талууд арбитрын бүрэлдэхүүнтэй харилцах аливаа харилцаа холбоог нарийн бичгийн дарга болон нөгөө талдаа заавал мэдэгдэх бөгөөд ийм харилцаа холбоог тэдгээрийг оролцуулан нэг цаг хугацаанд, хамтран явуулна. Аль нэг тал арбитрчтай ганцаарчилсан харилцаа холбоо тогтоох, уулзалт хийхийг хориглоно.
- 16.7. Хэрвээ хуралдааныг гадаад хэл дээр явуулах бол орчуулагч, хэлмэрч боломжтой бол спортын орчуулагч оролцуулна. Орчуулагч нь мэргэжлийн диплом, үнэмлэх, зөвшөөрөлтэй байхаас гадна хөндлөнгийн байх зарчмаар сонгогдсон байна.
- 16.8. Арбитрын бүрэлдэхүүн хэргийн оролцогчдын тайлбарыг сонссоны дараа нэмэлт материал цуглуулах шаардлагатай гэж үзвэл ажиллагааны аль ч үед гэрчээс мэдүүлэг авч, шинжээчийн дүгнэлтийг сонсож мөн хэргийн үнэн зөвийг тогтооход шаардлагатай гэж үзсэнбусад арга

хэмжээг авч хэрэгжүүлнэ

Арван долоо. Арбитрын ажиллагаа явуулах журмыг тодорхойлох

- 17.1. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн талуудын саналыг авч арбитрын үндсэн хуралдааны журмыг тодорхойлох урьдчилсан хуралдааныг зохион байгуулна. (Энэхүү заалт нь допингийн хэрэг, маргаанд хамаарахгүй бөгөөд допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн үед lex mitior зарчмыг тухайн хэргийн нөхцөл байдалд зохих ёсоор хэргийг хянан хэлэлцэж буй арбитрын бүрэлдэхүүн тогтоогоогүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй допингийн эсрэг дүрмээр зохицуулагдана)
- 17.2. Арбитрын үндсэн хуралдааны журмыг тогтоохдоо аль болох талуудын саналд тулгуурлах зарчмыг түлхүү баримтлах ба өөр өөр саналтай бол арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөж үндсэн хуралдааны журмыг хууль, энэхүү дүрэмд нийцүүлэн тогтооно. (Энэхүү заалт нь допингийн хэрэг, маргаанд хамаарахгүй бөгөөд допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн үед lex mitior зарчмыг тухайн хэргийн нөхцөл байдалд зохих ёсоор хэргийг хянан хэлэлцэж буй арбитрын бүрэлдэхүүн тогтоогоогүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй допингийн эсрэг дүрмээр зохицуулагдана)
- 17.3. Арбитрын ажиллагааны журамд дараах зүйлийг тусгана. Үүнд:
 - 17.3.1. Талуудын албан ёсны нэр, хаяг
 - 17.3.2. Арбитрын хэлэлцээр, түүний хүчин төгөлдөр эсэх талаар
 - 17.3.3. Арбитрын харьяалал
 - 17.3.4. Маргааны агуулга, нэхэмжлэлийн шаардлага
 - 17.3.5. Хариу тайлбар
 - 17.3.6. Арбитрын хураамж, зардал
 - 17.3.7. Тогтоох ёстой бусад асуудлууд /гэрч, шинжээч, үзлэг, нотлох баримт гаргуулах г.м./
 - 17.3.8. Арбитрын ажиллагаа явуулах газар, байршлын хаяг, харилцаа холбоо
 - 17.3.9. Арбитрын ажиллагаа явуулах хэл, бичиг
 - 17.3.10. Арбитрын ажиллагаанд хэрэглэх эрх зүй
 - 17.3.11. Арбитрын үндсэн хуралдааны тов
- 17.4. Арбитрын ажиллагааны журамд талууд болон арбитрын бүрэлдэхүүн гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэлбэрлэлтгүй сахина.
- 17.5. Арбитрын бүрэлдэхүүний даргалагч нь арбитрын урьдчилсан болон үндсэн хуралдааныг удирдана.
- 17.6. Даргалагч арбитрч нь арбитрын шийдвэр гаргах, шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах, арбитрын ажиллагааны журмыг тодорхойлох, арбитрчийг татгалзан гаргах, нөхөн томилохоос бусад асуудлаар, тухайлбал, арбитрын ажиллагааны явцад гарах горимын шинжтэй зарим асуудлыг дангаар шийдэж болно.

Арван найм. Арбитрын ажиллагаа, хуралдаан хийх газар

- 18.1. Арбитрын ажиллагаа явуулах газар болон хуралдаан хийх газрыг талууд харилцан тохиролцоно.
- 18.2. Хэрэв талууд харилцан өөрөөр тохиролцоогүй бол хэрэг, маргааныг зөв, шуурхай, бусдад чирэгдэл багатай, маргаан үүссэн нутаг дэвсгэрийн орон зай, зам тээврийн нөхцөл, гарах

зардал зэргийг харгалзан арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагаа явуулах газар болон хуралдаан хийх газрыг тодорхойлно.

- 18.3. Талууд өөрөөр тохиролцоогүй бол шаардлагатай тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн гэрч, шинжээч, талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигтүзлэг, шалгалт хийх зэрэг ажиллагааг арбитрын ажиллагаа явуулах газраас өөр газар явуулж болно.

Арван ес. Арбитрын ажиллагааны хэл, бичиг

- 19.1. Талууд Арбитрын ажиллагааг явуулах хэл, бичгийг тохиролцож өөрөөр тогтоож болно. Хэрэв талууд энэ талаар тохиролцоогүй бол хэрэглэх эрх зүй, маргааны агуулга, талууд аль улсын харьяат болох, тэдний сайн мэдэх хэл, бичиг зэргийг үндэслэн Арбитрын бүрэлдэхүүн ажиллагааны хэл, бичгийг сонгож тогтооно.
- 19.2. Энэхүү дүрмийн дагуу Арбитрын ажиллагаа явуулахаар тогтоосон хэл, бичгийг арбитрын бүхий л ажиллагаанд хэрэглэнэ.
- 19.3. Арбитрын ажиллагааны явцад тогтоосон хэл, бичгээс өөр хэл, бичгээр үйлдэгдсэн аливаа бичгэн нотлох баримтыг тогтоосон хэл рүү орчуулахыг талуудаас шаардана.
- 19.4. Бичгэн орчуулга нь орчуулга хийх эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажсан, талууд хүсвэл нотариатаар гэрчлүүлсэн байж болно.
- 19.5. Талууд монгол хэл, бичиг мэдэхгүй бол Арбитрын ажиллагаанд гадаад хэлний орчуулагч, хэлгүй, дүлий г.м. хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэг мэдэхгүй бол хэлмэрч оролцуулж болох бөгөөд энэхүү хэлмэрчлэл болон орчуулгын үнэн зөв болон зардлыг талууд өөрсдөө хариуцна.
- 19.6. Арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд талуудаас үл хамаарах хөндлөнгийн орчуулагч, хэлмэрч томилж болно. Хөндлөнгийн хэлмэрч, орчуулагч тусгай тэмдэгт, дохио зангаа ашигласан бол хэрэгт авч баталгаажуулах бөгөөд зардлыг талуудаас гаргуулна.
- 19.7. Талууд өөр өөр хэлээр харилцдаг бол Арбитрын бүрэлдэхүүн тэдний сайн мэдэх хэл дээр, ийм боломжгүй бол тус бүрийн орчуулагчийг оролцуулах журмаар төрөлх буюу сайн мэдэх хэл дээрээ тайлбар хийх, хуралдаанд оролцох, үг хэлэх боломжоор хангана.
- 19.8. Арбитрын бүрэлдэхүүнд хэд хэдэн улсын арбитрчид орсон нөхцөлд зөвхөн арбитрч нарын бие даасан орчуулагч оролцуулах бөгөөд түүнээс нууц хадгалах баталгаа гаргуулан авч зөвлөлдөх тасалгаанд орчуулагчийн тусламжийг авч болно.
- 19.9. Арбитрын ажиллагааны албан ёсны бичиг баримт нь Төрийн албан ёсны хэлний тухайхуулийн заалт шаардлагыг хангасан байна.

Хорь. Талуудын эрх, үүрэг

- 20.1. Талууд Спортын арбитрын ажиллагаанд тэгш эрхтэй оролцох бөгөөд өөрсдийн байр суурийг чөлөөтэй, харьцангуй бие даасан байдлаар, хөндлөнгийн нөлөөллөөс ангид нөхцөлд илэрхийлэх боломжоор бүрэн хангагдсан байх зарчмыг баримтална.
- 20.2. Талууд Спортын арбитрын ажиллагааны явцад тайлбар, хүсэлт гаргах, үг хэлэх, нотлох баримт гаргах, мэтгэлцэх эрхээ адил хэлбэр, хугацаа, удаа дараалалаар тэгш эдлэх боломжоор бүрэн дүүрэн хангагдсан байна. Харин энэхүү эрхээ эдлээгүй явдал тухай оролцогчийн хувийн асуудал бөгөөд эрхээ эдлэлгүй дараагийн ажиллагаанд оролцоод явсан бол уг эрхээ эдэлсэнтэй адилтган тооцно.
- 20.3. Спортын арбитрын ажиллагаанд оролцогч талууд нь дараах эрхийг эдэлнэ.
- 20.3.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хэргийн материалтай танилцах,

- хуулбарлан авах, тэмдэглэл үйлдэх, Спортын арбитрын хуралдааны үед даргалагч арбитрчийн зөвшөөрлөөр бусад оролцогчдод асуулт тавих, хариулт авах
- 20.3.2. Шинжээч томилуулах, үзлэг явуулах, гэрч асуулгах, хэлмэрч, орчуулагч оролцуулах тухай хүсэлт гаргах
- 20.3.3. Спортын арбитрын бүрэлдэхүүн, арбитрч, шинжээч, орчуулагч, гэрч, хэлмэрч бусад этгээдийг арбитрын ажиллагаанд оролцуулахаас татгалзах
- 20.3.4. Нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргасан үндэслэл буюу нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, эсхүл нэхэмжлэлээс бүрмөсөн татгалзах, эвлэрэн хэлэлцэх
- 20.3.5. Хариуцагч нь нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх, татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэн хэлэлцэх
- 20.3.6. Хуульд заасан үндэслэл болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хурал хойшлуулах хүсэлт гаргах
- 20.4. Спортын арбитрын ажиллагаанд оролцогч талууд нь дараах үүргийг хүлээнэ.
- 20.4.1. Спортын арбитрын Ажлын алба, нарийн бичгийн даргын дуудсан хугацаанд арбитрт ирж нэхэмжлэлээ гардан авах, арбитрын хуралдаанд хүрэлцэн ирэх, биечлэн оролцох
- 20.4.2. Нэхэмжлэл болон татгалзлын үндэслэл болох нөхцөл байдлыг өөрсдөө амаар болон бичгээр нотлох. Бичмэл нотлох баримтыг арбитрт эхээр нь, хэрэв эхийг өгөх боломжгүй бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Хуулбарыг өгсөн үед шаардлагатай гэж үзвэл Спортын арбитр жинхэнэ эхийг шаардан авах эрхтэй. Бичмэл нотлох баримтыг шаардан авахад бэрхшээлтэй байвал зохигчийн хүсэлтээр түүний хадгалагдаж байгаа газарт нь үзлэг явуулах ба шинжлэн судалж болно.
- 20.4.3. Спортын арбитрын хавтаст хэрэгт гаргаж өгсөн нэхэмжлэл болон бусад бичиг баримтын хуулбарыг нөгөө талд илгээх
- 20.5. Спортын арбитрын бүрэлдэхүүн болон нарийн бичгийн даргаас тавьсан шаардлага, Спортын арбитрын бүрэлдэхүүний гаргасан шийдвэрийг хүндэтгэн биелүүлэх Талууд иргэн бол арбитрын ажиллагаанд төлөөлөгч оролцуулахдаа эдлэх эрх, үүргийг нь тодорхойлсон, нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг арбитрт ирүүлнэ. Харин талууд хуулийн этгээд бол албан бичгээр итгэмжлэл олгож болно.
- 20.6. Итгэмжлэл Монгол улсын Иргэний хуулийн 64 дүгээр зүйлд заасан шаардагыг хангах бөгөөд нэмэлтээр электрон шуудангийн хаяг, харилцах утасны дугаарыг тусгасан байна.
- 20.7. Өмгөөлөгч оролцох бол эрх зүйн туслалцааны гэрээ хийгдсэн байна. Талууд болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч арбитрын ажиллагааны тухай мэдэгдлийн дагуу оролцоогүй, арбитрын хуралдаанд ирээгүй, эсхүл хуралдааны явцад хурлыг орхин гарсан нөхцөлд, нөгөө талын саналыг харгалзан хуралдааныг хойшлуулах, эсхүл хуралдааныг ердийн журмаар үргэлжлүүлнэ.

Хорин нэг. Гуравдагч этгээд

- 21.1. Талууд арбитрын ажиллагаанд гуравдагч этгээдийг татан оролцуулах талаар хүсэлт гаргах эрхтэй бөгөөд хүсэлтээ нотолсон холбогдох баримт бичгийг хавсаргана. Спортын Арбитрын бүрэлдэхүүн хүсэлтийг хүлээн авсан бол арбитрын Ажлын алба нь гуравдагч этгээдээр татагдсан этгээдэд шийдвэр, хүсэлт түүний хавсралтуудыг танилцуулах бөгөөд тайлбар гаргах хугацааг тогтоож өгнө.
- 21.2. Хэрэв гуравдагч этгээд нь арбитрын ажиллагаанд оролцохоос татгалзвал энэ тухайгаа

оролцогчийн мэдэгдэл гардаж авснаас хойш 10 хоногийн дотор шалтгаанаа нотлох баримтын хамт бичгээр ирүүлнэ. Ажлын алба нь хэргийн оролцогчдод гуравдагч этгээдийн хүсэлтийг танилцуулан үүнтэй холбогдуудан тэдний саналыг авна.

- 21.3. Гуравдагч этгээд нь арбитрын хэлэлцээрийн гэрээгээр үүрэг хүлээсэн эсхүл хэргийн оролцогчид тохиролцон бичгээр хэлэлцээр хийсэн бол арбитрын ажиллагаанд оролцохоос татгалзах эрхгүй.
- 21.4. Арбитрын хэргийн нотлох баримт нь талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл /гэрээ хэлэлцээр, протокол, тодорхойлолт, төлбөрийн даалгавар, тооцооны баримт, тооцоо нийлсэн акт, хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлэг, чанарын сертификат гэх мэт/ болон электрон хэлбэр дэх баримтууд, шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт, үзлэгийн тэмдэглэл зэргээс бүрдэнэ.

Хорин хоёр. Нотлох баримт гаргах ба цуглуулах

- 22.1. Арбитрын хэргийн нотлох баримт нь талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл /гэрээ хэлэлцээр, протокол, тодорхойлолт, төлбөрийн даалгавар, тооцооны баримт, тооцоо нийлсэн акт, хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлэг, чанарын сертификат гэх мэт/ болон электрон хэлбэр дэх баримтууд, шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт, үзлэгийн тэмдэглэл зэргээс бүрдэнэ.
- 22.2. Спортын Арбитрын нарийн бичгийн дарга нь хэргийг хянан шийдвэрлэх бэлтгэл ажиллагааны явц байдлыг арбитрын бүрэлдэхүүн\даргалагч\-д долоо хоногт нэгээс доошгүй удаа утсаар болон биечлэн танилцуулах бөгөөд зарим даалгаврыг арбитрч нь Спортын арбитрын нарийн бичгийн даргад өгч гүйцэтгүүлнэ.
- 22.3. Шаардлагатай бол талуудаас нэмэлт нотлох баримт шаардах бөгөөд эдгээрийг арбитрт ирүүлэх хугацааг тогтооно.
- 22.4. Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас харьцуулах, жиших аргачлалаар үнэлэх нь арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрхэд хамаарна.
- 22.5. Талууд тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа нөхцөл байдлыг өөрөө нотлох үүрэгтэй.
- 22.6. Талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь хуурамч нотлох баримт гаргах буюу хууль бус аргаар цуглуулахыг хориглоно. Ийм арга хэлбэрээр гаргасан нотлох баримт нь нотлох чанараа алдах бөгөөд арбитрын шийдвэрийн үндэслэл болохгүй.
- 22.7. Нотлох баримтыг арбитрын хуралдаан эхлэхээс өмнө долоогоос доошгүй хоногийн өмнө арбитрт ирүүлэх бөгөөд хэрэв энэхүү хугацаа хэтэрвэл нотлох баримтыг хүлээж авах эсэхийг арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.
- 22.8. Арбитрын хуралдааны үед шинэ нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл арбитрын бүрэлдэхүүн арбитрын хуралдааныг хойшлуулж болно.
- 22.9. Нотлох баримт бүрдүүлэхэд шүүх болон бусад байгууллага туслалцаа үзүүлнэ.

Хорин гурав. Хэргийн бодит нөхцөл байдлыг тогтоох

- 23.1. Арбитрын бүрэлдэхүүн маргааны бодит байдлыг тогтооно. Ийнхүү тогтоохдоо арбитрын бүрэлдэхүүн гэрч дуудах, шинжээч томилох, үзлэг хийх болон баримт бичиг нэмж гаргуулах, хуулиар зөвшөөрсөн бусад ажиллагаа- /туршилт хийх, даалгавар бичих г.м /-г хийнэ.
- 23.2. Шаардлагатай бол талуудын хүсэлт болон бүрэлдэхүүнээс шинжээчийн дүгнэлт гаргуулахаар

- нарийн мэргэжлийн, хөндлөнгийн шинжээч томилно.
- 23.3. Шинжээч нь зарчмын хувьд тухайн томилгоог хүлээн авахын өмнө арбитрын бүрэлдэхүүнд өөрийн мэргэшил болон бие даасан, талуудаас хараат бус байдлын талаарх мэдэгдлийг ирүүлнэ.
 - 23.4. Шинжээч нь шаардлагатай гэж үзвэл тухайн хэргийн материалтай танилцах, нэмэлт материал гаргаж өгөхийг арбитраас болон талуудаас шаардах, үзлэг хийх эрхтэй.
 - 23.5. Арбитрын шийдвэр гаргахад ашиглаж буй шинжээчийн дүгнэлт, нотолгооны шинжтэй бусад баримт бичгийг арбитрын бүрэлдэхүүн талуудад мөн нэг адил хүргүүлнэ.
 - 23.6. Шинжээч дүгнэлтийг шударгаар гаргах нь эргэлзээтэй гэж үзвэл талууд түүнээс татгалзаж болно. Ийнхүү татгалзан гарах асуудлыг арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.
 - 23.7. Аль нэг шинжээч нь бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлт, тайлбараа тусад нь гаргаж болно.
 - 23.8. Арбитрын бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэх, шинжээч дүгнэлт гаргахдаа зарим байдлыг тодруулахын тулд бараа эд зүйлс, баримт бичигт үзлэг хийж болно.
 - 23.9. Үзлэгийг хэргийн оролцогчдыг оролцуулан хийж, тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогчид ирээгүй явдал нь үзлэг хийхэд саад болохгүй.
 - 23.10. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан бусдаас нарийн мэргэжлийн тусламж авч болно. Үүнд маргаантай шийдвэрийг гаргасан холбоо, нийгэмлэг болон спортод холбоотой байгууллагуудаас санал авах ажиллагаа хамаарна.
 - 23.11. Талууд арбитрын бүрэлдэхүүний шаардсан бичиг баримт, бодит нотлох баримт болон бусад нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, тогтсон хугацаанд гаргаж өгөөгүй бол арбитрын бүрэлдэхүүн хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд шийдвэр гаргаж болно.
 - 23.12. Арбитрын бүрэлдэхүүн болон талууд арбитрын хуралдаанд гэрч оролцуулж болно, эсхүл гэрчээс урьдчилан мэдүүлэг авч болно.
 - 23.13. Хэргийн оролцогчид, гэрч нарыг хуралдаанд ирэхийг мэдэгдсэн боловч хүрэлцэн ирээгүй байсан ч хуралдааныг явуулан, арбитрын шийдвэрийг гаргана.

Хорин дөрөв. Тэмдэглэл

- 24.1. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан болон хуралдаанаас гадуур явагдсан бусад ажиллагааны талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлийг хуралдааны нарийн бичгийн дарга хөтөлнө. Тэмдэглэлд хуралдаан даргалагч болон хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, албажуулна.
- 24.2. Тэмдэглэлд хуралдаан болон ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, түүний эхэлсэн, дууссан цаг, түүнд оролцогчдын овог нэр, хаяг, түүнчлэн үйл ажиллагааны дэс дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ.
- 24.3. Арбитрын хуралдааны явц болон бусад ажиллагааг зөвхөн арбитрын нарийн бичгийн дарга, шаардлагатай бол мэргэжлийн байгууллага, ажилтнаар техник хэрэгслэл ашиглан дуу, дүрс, фото, бичлэг хийх, хуулбарлан буулгаж болно.
- 24.4. Хэргийн оролцогчид хуралдааны тэмдэглэлтэй танилцаж болно. Энэ тохиолдолд танилцсан этгээдээр гарын үсэг зуруулсан байна.

Хорин тав. Талууд үүргээ биелүүлэхгүй байх

- 25.1. Нэхэмжлэгч шаардлагаа тодорхойлоогүй, мөнгөн дүнгээр илэрхийлээгүй, үйл баримт холбогдох баримтаа ирүүлээгүй, энэ талаар тогтоосон хугацаа дууссан бол арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргаж болно.
- 25.2. Хариуцагч тогтоосон хугацаанд хариу тайлбараа ирүүлээгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож болох хууль зүйн зохицуулалттай учраас арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг үргэлжүүлэн явуулна.
- 25.3. Талууд арбитрын ажиллагааны талаар болон хуралдааны товыг албан ёсоор хүлээн авсан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй, эсхүл тогтоосон хугацаанд нотлох баримтаа гаргаж өгөөгүй бол арбитрын бүрэлдэхүүн ажиллагааг үргэлжлүүлж, цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргана.

Хорин зургаа. Арбитрын урьдчилсан хуралдаан

- 26.1. Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 52 дугаар зүйлийн 52.4-д заасны дагуу маргаанаа Спортын Арбитраар шийдвэрлүүлэхээр талууд бие даасан арбитрын хэлэлцээр хийсэн, эсхүл спортын арга хэмжээний гэрээндээ тусгасан, мөн маргаан үүссэний дараа тохиролцсон, түүнчлэн аль нэг тал Спортын Арбитраар шийдвэрлэхийг эсэргүүцээгүй, хүлээн зөвшөөрсөн үйлдэл хийсэн бол арбитрын хэлэлцээртэй адилтган үзнэ.
- 26.2. Аливаа спортын холбоо, нийгэмлэг болон бусад спорттой холбоотой байгууллагуудын хооронд, эсхүл тамирчдын хооронд, түүнчлэн спортын байгууллага - тамирчдын хоорондын спортын аливаа арга хэмжээний тухай гэрээ, тамирчинтай байгуулсан контракт, Тамирчны үйл ажиллагааны гэрээ, дасгалжуулагчтай байгуулах гэрээнээс үүссэн зөвхөн спорттой шууд холбоо бүхий хэрэг маргааныг энэхүү дүрэм журмын дагуу арбитраар шийдвэрлэнэ. Тухайн байгууллагын дүрэм, журам эсхүл тусгайлан үйлдсэн арбитрын хэлэлцээртэй байж болно.
- 26.3. Арбитрын хэлэлцээртэй гэж тооцох үндсэн нөхцлүүд:
- 26.4. Спортын маргааныг арбитрын байгууллагаар шийдвэрлүүлэхийн тулд дараах нөхцлийг бичгээр илэрхийлсэн байна:
 - 26.4.1. Аливаа спортыг зохион байгуулах үйл ажиллагааны гэрээнд “Маргааныг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитраар шийдвэрлүүлнэ” гэж тусгасан байх
 - 26.4.2. Олон улсын ба Үндэсний Спортын Арбитрын бие даасан тусгай хэлэлцээр хийсэн байх /загвар гэрээг хавсаргав/.
 - 26.4.3. Маргаан үүссэний дараа мэтгэлцэгч талууд маргаанаа Спортын Арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсон,
 - 26.4.4. Арбитрт хэлэлцээргүйч арбитрт шууд хандах, нөгөө тал үүнийг нь эсэргүүцээгүй, хүлээн зөвшөөрсөн, хариу тайлбар, нотлох баримт гаргаж мэтгэлцсэн нөхцөлд арбитрын хэлэлцээр хийсэнтэй адилтган үзэх,
- 26.5. Арбитрын бүрэлдэхүүн маргааныг арбитрын харьяаллын маргаан мөн эсэхийг тогтоох бөгөөд талууд арбитрын хэлэлцээртэй эсэх, тухайн хэлэлцээр хүчин төгөлдөр эсэхийг шийдвэрлэнэ.
- 26.6. Гэрээний арбитрын заалтыг гэрээний бусад нөхцөл хүчинтэй эсэхээс үл хамаарч бие даасан, арбитрын хэлэлцээртэй, хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 26.7. Талууд харьяаллын талаар гомдол гаргахаар бол нэхэмжлэлд тайлбар гаргахаасаа өмнө тус арбитрын бүрэлдэхүүнд гаргана. Нэхэмжлэлийг хүлээн авсан, арбитрч сонгосон, харьяаллын талаар тайлбар гаргасан, урьдчилсан хуралдаанд оролцсон нь арбитрын хэлэлцээр болон харьяаллыг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
- 26.8. Шүүх, бусад эрх бүхий байгууллага шийдвэрлэхээр хуулиар тусгайлан харьяалал тогтоосон

аливаа хэрэг, маргаанаас бусад, зөвхөн спорттой шууд холбоо бүхий, Арбитрын тухай хууль болон хэлэлцээрт тусгайлан заасан спортын маргааныг тус арбитр харьяалан хянаж шийдвэрлэнэ.

Хорин долоо. Арбитрын үндсэн хуралдаан

- 27.1. Спортын Арбитрын хуралдаанд талуудыг оролцуулж хийх, эсхүл оролцуулахгүйгээр хийх гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулж болно. Талууд арбитрын хуралдаанд биечлэн оролцохгүй, арбитрын бүрэлдэхүүнд итгэл үзүүлэн маргааныг цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэрлүүлэх хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн хэрэгт авагдсан нотлох баримтын үндсэн дээр хэргийг зөвлөлдөх журмаар шийдвэрлэж болно.
- 27.2. Талууд арбитрын хуралдаанд оролцохоор тохиролцсон, эсхүл аль нэг тал ийнхүү хүсэлт гаргасан бол арбитрын бүрэлдэхүүн талуудыг оролцуулан арбитрын хуралдааныг мэтгэлцэх зарчмаар явуулж хэргийг шийдвэрлэнэ.
- 27.3. Арбитрын хуралдаан болох газар, огноог талуудад урьдчилан /харилцаа холбооны бүх боломжит хувилбараар/ мэдэгдэнэ.
- 27.4. Арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэхдээ хэргийн талаар авагдсан нотлох баримтыг бүх талаас нь шинжлэн судалж, хэргийн оролцогчдын шаардлага, тайлбарыг сонсож, талуудыг тайлбар хийх адил боломжоор хангалттай хангагдсан гэж үзсэн тохиолдолд зөвлөлдөхөөр арбитрын хуралдааныг завсарлана.
- 27.5. Арбитрын хуралдаан завсарласнаар арбитрын бүрэлдэхүүн тусгайлан зөвлөлдөх бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачилгаар арбитрын шийдвэр гаргахаас өмнө хуралдааныг дахин үргэлжлүүлж болно.
- 27.6. Арбитрчид тусгайлан зөвлөлдөхдөө хаалттай хийх ба зөвлөлдөх тасалгааны нууцыг чандлан хадгална.
- 27.7. Арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөж олонхийн саналаар шийдвэрээ гаргах бөгөөд зөвлөлдөх хугацааг хязгаарлахгүй, арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийн агуулгыг танилцуулж хуралдааныг хаана.

Хорин найм. Талууд эвлэрэн хэлэлцэх

- 28.1. Арбитрын ажиллагааны явцад болон арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөхөөс өмнө талууд маргааны талаар эвлэрэн хэлэлцэж болно.
- 28.2. Арбитрын бүрэлдэхүүний шийдвэр гарахаас өмнө талууд эвлэрэхээр санал нэгдсэн бол арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргах, эсхүл талууд эвлэрэн хэлэлцсэнээ арбитрын шийдвэрт тусгуулах хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн татгалзаагүй бол эвлэрлийн нөхцөлийг арбитрын шийдвэрт тусгаж баталгаажуулна. Шийдвэрт түүнийг гаргасан үндэслэлийг заахгүй байж болно.
- 28.3. Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шийдвэр нь арбитрын бүрэлдэхүүний хэрэг хянан шийдвэрлэсэн тухай шийдвэрийн адил хүчинтэй.
- 28.4. Спортын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрүүлэнзуучлалын журмаар эвлэрэн хэлэлцэх хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид хандах боломжийг талуудад хуульд заасан хугацаагаар олгоно.

Хорин ёс. Арбитрын шийдвэр

- 29.1. Арбитрын бүрэлдэхүүнээс гарах аливаа шийдвэрүүдийг олонхийн саналаар гаргана. Харин арбитрын бүрэлдэхүүн өөр өөр санал гаргасан тохиолдолд хэрэг маргааныг шийдвэрлэж чадаагүйд тооцож, хэргийг өөр бүрэлдэхүүнээр шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ.
- 29.2. Бүхий л шийдвэрийг бичгээр үйлдэх бөгөөд үүнийг талууд заавал дагаж мөрдөх бөгөөд тогтоосон хугацаанд нь биелүүлэх үүрэгтэй.
- 29.3. Арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөөд гаргасан шийдвэрийнхээ агуулгыг талуудад танилцуулах бөгөөд ийнхүү танилцуулахад талууд оролцохгүй байж болно. Арбитрын шийдвэрийг агуулгыг танилцуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор бичгээр үйлдэж, ёсчилсон буюу албажуулсан байна.
- 29.4. Шийдвэрийн дүгнэлтийн болон тогтоох хэсгийг хуралдаан даргалагч үйлдэж, Ажлын алба бусад хэсгийг нэгтгэн, бусад арбитрч нарын саналыг авч, алдааг хянаж, гарын үсэг зуруулах, тамга, тэмдэг дарах, дугаар өгөх ажиллагааг гүйцэтгэнэ.
- 29.5. Арбитрын шийдвэр гаргасан огноог арбитрын хуралдаан явуулсан тохиолдолд шийдвэрийн агуулгыг танилцуулсан өдөр, харин Арбитрын хуралдаан явуулалгүй шийдвэр гаргасан тохиолдолд арбитрчид шийдвэрт гарын үсэг зурсан өдөр байна.
- 29.6. Арбитрын бүрэлдэхүүн арбитрын шийдвэрийн эх хувийг хэрэгт, зохигчид, оролцогсодын зохих тоогоор үйлдэнэ. Ажлын алба шийдвэрийн нэг хувийг хавтаст хэрэгт хадгалж, бусад эх хувийг талуудад нэн даруй гардуулах буюу хүргүүлнэ.
- 29.7. Арбитрын ажиллагааны явцад гарсан нэмэлт зардлыг талууд бүрэн төлөх хүртэл арбитрын шийдвэрийг талуудад хүргүүлэх ажиллагааг хойшлуулж болно.

Гуч. Арбитрын ажиллагааг дуусгавар болгох

- 30.1. Арбитрын ажиллагааг дуусгавар болгохдоо Арбитрын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасныг баримтална. Мөн доорх үндэслэлээр арбитрын ажиллагааг дуусгавар болгоно.
 - 30.1.1. Тус арбитрын харьяаллын маргаан биш болох нь тогтоогдсон
 - 30.1.2. Талууд эвлэрсэн, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, шийдвэр гарахаас өмнө сайн дураар биелүүлсэн, нэхэмжлэлээ татан авсан, нэхэмжлэлээсээ татгалзсан
 - 30.1.3. Талууд арбитрын зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй
 - 30.1.4. Талууд арбитрын бүрэлдэхүүний шаарлагыг биелүүлээгүй, арбитрын ажиллагаанд оролцоогүй, идэвхигүй оролцсон, эсхүл арбитрын ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй болсон
- 30.2. Арбитрын шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргахдаа Арбитрын тухай хуулийн 46 дугаар зүйлийг баримтална.
- 30.3. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухайгаа талуудад бичгээр мэдэгдэнэ.

Гучин нэг. Арбитрын шийдвэрийг биелүүлэх

- 31.1. Спортын Арбитрын шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болмогц заавал биелэгдэх ёстойбөгөөд талууд шийдвэрийг хүндэтгэн биелүүлэх үүрэгтэй.

31.2. Спортын Арбитрын шийдвэр нь тус улсын нутаг дэвсгэрт, түүнчлэн гадаад улсад гүйцэтгэгдэнэ.

Гучин хоёр. Спортын Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах журам

- 32.1. Талууд арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулахаар тохиролцож болно.
- 32.2. Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулахаар бол маргаан шийдвэрлэх арбитрын бүрэлдэхүүн нэг арбитрчаас бүрдэх бөгөөд тухайн арбитрчийг Арбитрын Ерөнхийлөгч томилно.
- 32.3. Арбитрч арбитраас хэргийн материал хүлээн авсан даруйд арбитрын ажиллагаа явуулах журмыг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай энэхүү дүрмийн 17 дугаар зүйлийн 17.3-д заасан асуудлаар өөрсдийн саналыг 7 хоногийн дотор бичгээр ирүүлэхийг талуудаас шаардана.
- 32.4. Арбитрч арбитрын ажиллагааг явуулах журмыг талуудын урьдчилан бичгээр ирүүлсэн саналын үндсэн дээр тодорхойлох бөгөөд хэрэв талууд санал зөрвөл арбитрч өөрөө тодорхойлно.
- 32.5. Арбитрч арбитрын ажиллагаа явуулах журмыг бичгээр гарган, гарын үсэг зуран баталгаажуулж талуудад хүргүүлнэ.

Гучин гурав. Гомдол гаргах

- 33.1. Спортын маргааны хянан шийдвэрлэх явцад гарсан шийдвэрийн талаар гаргасан гомдлыг Арбитрын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэнэ.
- 33.2. Талууд арбитрын анхан шатны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Тухайн арбитрын ажиллагаа явагдсан нутаг дэвсгэрийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд, хуульд заасан хугацааны дотор гомдол гаргаж болно. (Энэхүү заалт нь допингийн хэрэг, маргаанд хамаарахгүй бөгөөд допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн үед lex mitior зарчмыг тухайн хэргийн нөхцөл байдалд зохих ёсоор хэргийг хянан хэлэлцэж буй арбитрын бүрэлдэхүүн тогтоогоогүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй допингийн эсрэг дүрмээр зохицуулагдана.)
- 33.3. Давж заалдах гомдол нь Арбитрын ажиллагааны явцад хэргийн оролцогчийн хуулиар олгосон эрхийг эдлүүлсэн эсэхээр хязгаарлагдана. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа ямар эрхийг, хэрхэн эдлүүлээгүй талаарх хууль зүйн үндэслэл, нотолгоог заана. (Энэхүү заалт нь допингийн хэрэг, маргаанд хамаарахгүй бөгөөд допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн үед lex mitior зарчмыг тухайн хэргийн нөхцөл байдалд зохих ёсоор хэргийг хянан хэлэлцэж буй арбитрын бүрэлдэхүүн тогтоогоогүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй допингийн эсрэг дүрмээр зохицуулагдана)
- 33.4. Гомдол гаргагч нь давж заалдах шатанд арбитрын хураамжийг хуульд заасан хэмжээгээр төлсөн байх ёстой.
- 33.5. Гомдол гаргах хугацаа нь шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 30 хоног байна.
- 33.6. Ажлын алба хариуцагчид гомдлыг танилцуулах ба хариуцагч гомдолд бичгээр 7 хоногийн хугацаанд тайлбар гаргах эрхтэй.
- 33.7. Ажлын алба нь арбитрын хэрэг, давж заалдах гомдол, гомдлын үндэслэл, хариу тайлбар зэрэг холбогдох баримт бичгийг давж заалдах шатны шүүхэд илгээнэ.

Гучин дөрөв. Хариуцлагаас чөлөөлөгдөх

- 34.1. Арбитрчид хэрэг шийдвэрлэхтэй холбоотой үүргээ санаатайгаар зөрчснөөс бусад үйлдлийн төлөө хариуцлага хүлээхгүй.
- 34.2. Арбитрчид, Ажлын албаны ажилтнууд Спортын арбитрын ажиллагааны явцад санаатайгаар үүргээ зөрчсөн буюу ноцтой үр дагавар бүхий эс үйлдэл гаргаснаас бусад үйлдэл, эс үйлдлийн төлөө хариуцлага хүлээхгүй.

Гучин тав. Нууцлал

- 35.1. Спортын Арбитрын бүрэлдэхүүн болон арбитрч, талууд, бусад оролцогсод, Ажлын албаны ажилтан, гэрч, шинжээч арбитрын ажиллагаанд оролцсон бүх этгээд Спортын Арбитрын ажиллагааны талаар болон нотлох баримтын талаарх нууцыг хадгалах үүрэгтэй.
- 35.2. Спортын Арбитр хэрэг, маргааныг шийдвэрлэсэн шийдвэрийг талуудын зөвшөөрөлгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэхгүй, нэвтрүүлэхгүй. Харин бүх шийдвэрийн нэгдсэн эмхэтгэл гаргах, статистик тоон мэдээллийг гаргах шаарлага гарсан үед оролцогсдын нэр, хаягийг өөрчлөх, эсхүл нэргүйгээр хэвлэн нийтэлж болно. Энэ тохиолдолд Ерөнхийлөгчийн тушаалаар шийдвэрлэнэ.

Гучин зургаа. Арбитрын шийдвэрийг гүйцэтгэх шүүгчийн захирамж, гүйцэтгэх хуудас, биелүүлэх ажиллагаа

- 36.1. Арбитрын шийдвэрийг албадан биелүүлэх тухай болон гүйцэтгэх хуудас бичүүлэх тухай хүсэлт, арбитрын шийдвэр, шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон тодорхойлолтын хамт арбитрын ажиллагаа явагдсан тухайн орон нутгийн анхан шатны шүүхэд гаргана.
- 36.2. Шүүх хүсэлтийг хүлээн авсан нөхцөлд Шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандаж арбитрын шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авна.
Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын шийдвэрийг бусад улсад биелүүлэх бол Олон Улсад биелүүлэх Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцид Монгол Улс 1994 онд нэгдэн орсон тул Спортын Арбитрын шийдвэрийг дээрхи конвенцийн дагуу дэлхийн бусад улс оронд (энэ дүрэм батлагдах өдрийн байдлаар нийт 155 улс нэгдэн оржээ) гүйцэтгэнэ.
- 36.3. Спортын Арбитрын шийдвэрийг гадаад улсад гүйцэтгэх бол 1958 оны Нью-Йоркийн конвенцийн заасан баримт бичгийг бүрдүүлэхээс гадна дээр дурдсан баримт бичгийг нэмэлтээр бүрдүүлнэ.

Гучин долоо. Арбитрын шийдвэрийн биелэлтийг дүгнэх

- 37.1. Олон Улсад биелүүлэх Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцид нэгдсэн улс оронд гүйцэтгэгдсэн шийдвэрийн талаар нэхэмжлэгч, эсхүл тухайн улсын холбогдох байгууллагаас лавлагаа авч хэрэгт хавсаргана.
- 37.2. Спортын Арбитрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гүйцэтгэсэн талаар лавлагааг нэхэмжлэгч, хариуцагч, шийдвэр гүйцэтгэх газраас лавлагаа авч хэрэгт

хавсаргана.

- 37.3. Гадаад Улсын Спортын арбитрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт биелүүлсэн тухай лавлагааг мөн холбогдох газраас авч, Монголын спортын арбитрын шийдвэрийг биелүүлсэн талаар нэгдсэн мэдээллийн санд оруулах ажиллагааг Ажлын алба хариуцан гүйцэтгэнэ.

Гучин найм. Дүрмийн хүчин төгөлдөр байдал

- 38.1 Энэхүү дүрэм 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

